



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442584

Цахим шуудан:procurement.bayankhongor@audit.gov.mn

Г ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАЯНХОНГОР АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО-д

2022.04.18 № 1/304

танай _____ -ны № _____ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох Баянхонгор аймгийн "Ардчилсан нам"-аас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Баянхонгор аймгийн "Ардчилсан нам"-ын хорооны Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцохор ирүүлсэн сонгуулийн мөрийн

D-Alban bichig 2022 A4 TOOT

• 005020753

хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлогод тус тус нийцсэн байна.

"Ардчилсан нам"-ын хорооны мөрийн хөтөлбөр /4 хуудас /-ыг хавсаргав.

Хувийг: Баянхонгор аймгийн Өлзийт сумын Сонгуулийн хороонд
Хавсралт⁸ хуудастай.

